



28

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

Хяналтын хуудас, шалгуур үзүүлэлт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 344 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2013 оныг “Хариуцлага хяналтыг сайжруулах” жил болгон зарласантай холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, “Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээ”-ний гүйцэтгэл, хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хуудас, шалгуур үзүүлэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү хяналтын хуудсын дагуу удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавихыг холбогдох газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, ерөнхий эмч нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А. Эрдэнэтуяа)-д даалгасугай.

САЙД



Н. УДВАЛ

002927

29

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 сарын 06-ны өдрийн
458 тоот тушаалын хавсралт

**Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээний удирдамжийн хэрэгжилтэд
хяналт тавих хяналтын хуудас, шалгуур үзүүлэлт**


Нэг. Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллагад “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх цэгтэй	
2	Иргэд, үйлчлүүлэгчийг угтан авах ажилтантай	
3	“Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” тогтмолжсон байдал	
4	“Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх цэг нь иргэд, үйлчлүүлэгчдийн орж ирэх хаалганы ойролцоо байрласан	
5	Байгууллага нь албажуулсан “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх удирдамжтай	
6	Удирдамжийн агуулга: <ul style="list-style-type: none">- ажилтны хувцаслалт,- зан харилцаа,- үйлчилгээ үзүүлэх үед шаардагдах мэдээлэл,- угтах үйлчилгээ үзүүлэх журам	
7	“Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
8	“Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ”-ний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	

Хоёр. Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Эрүүл мэндийн байгууллага бүр иргэд, үйлчлүүлэгчид утсаар, бичгээр болон аман хэлбэрээр аливаа мэдээллийг лавлаж асуух асуултанд хариулж, үйлчилгээ үзүүлэх лавлах цэгтэй	
2	Байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ” үзүүлэх удирдамжтай	
3	Удирдамжийн агуулга: <ul style="list-style-type: none">- лавлагаа өгөх тусламж, үйлчилгээний төрөл,- тэдгээрийн тухай лавлагаа өгөх мэдээллийн сан,	

	<ul style="list-style-type: none"> - лавлагаа өгч байгаа ажилтны ажлын байрны тодорхойлолт - ажиллах журам 	
4	“Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ” үзүүлэх талаар бүх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
5	Лавлах үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй, харагдахуйц, хангалттай хэмжээнд байрлуулсан	
6	“Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ”-ний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	




Гурав. Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдийг гэр бүлийн гишүүд, найз нөхөд эргэх ая тухтай орчинг бүрдүүлсэн байдал	
2	Эргэх үйлчилгээний уулзалтын хэсэгтэй	
3	Байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ” үзүүлэх удирдамжтай	
4	Удирдамжийн агуулга: <ul style="list-style-type: none"> - Эргэлтийн цагийн хуваарь, - Эргэлт ирсэн тухай мэдээлэл, - Эргэлтийн байрны ажиллах журам 	
5	Эргэлт ирсэн тухай эмчлүүлэгчдэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байдал	
6	“Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ” үзүүлэх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
7	“Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ”-ний талаарх иргэд, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	

Дөрөв. Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ” үзүүлэх удирдамжтай	
2	“Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ” үзүүлэх талаар бүх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	

3	“Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ”-ний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	
---	--	--



31

Тав. Сэтгэлд нийцсэн оношилгоо

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн оношилгоо” хийх удирдамжтай	
2	“Сэтгэлд нийцсэн оношилгоо” хийх талаар бүх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
3	“Сэтгэлд нийцсэн оношилгоо” нь байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан байдал	
4	Байгууллага нь ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтэд “Сэтгэлд нийцсэн оношилгоо”-ны үзүүлэлтийг оруулсан байдал	
5	“Сэтгэлд нийцсэн оношилгоо” хийх үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	

Зургаа. Сэтгэлд нийцсэн эмчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллага нь “Сэтгэлд нийцсэн эмчилгээ” хийх удирдамжтай	
2	“Сэтгэлд нийцсэн эмчилгээ” хийх талаар бүх ажилтныг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
3	“Сэтгэлд нийцсэн эмчилгээ” нь байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан байдал	
4	Байгууллага нь ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтэд “Сэтгэлд нийцсэн эмчилгээ”-ний үзүүлэлтийг оруулсан байдал	
5	“Сэтгэлд нийцсэн эмчилгээ” хийх үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	

Долоо. Сэтгэлд нийцсэн сувилгаа



№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллага нь “Сэтгэлд нийцсэн сувилгаа” үзүүлэх удирдамжтай	
2	“Сэтгэлд нийцсэн сувилгаа” үзүүлэх талаар бүх сувилагч, туслах сувилагчдыг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
3	“Сэтгэлд нийцсэн сувилгаа” нь байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан байдал	
4	Байгууллага нь ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтэд “Сэтгэлд нийцсэн сувилгаа”-ний үзүүлэлтийг оруулсан байдал	
5	“Сэтгэлд нийцсэн сувилгаа” хийх үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	

Найм. Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл
1	Байгууллага нь “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” үзүүлэх удирдамжтай	
2	“Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” үзүүлэх талаар эмч, сувилагч, туслах сувилагчдыг сургалтад хамруулсан байдал (сургалтын хөтөлбөр, олгосон гэрчилгээ)	
3	“Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” нь байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан байдал	
4	Байгууллага нь ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтэд “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ”-ний үзүүлэлтийг оруулсан байдал	
5	“Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ” хийх үйлчилгээний талаар иргэд, үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчдийн сэтгэгдэл, сэтгэл ханамжийн байдал	